УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/80/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2022 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Б.Одгэрэл<br>Утас: 70453721, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3
3. Аудитын тайлан ....11
   3.1 Ерөнхий зүйл ....11
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....11
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....11
   3.4 Материаллаг байдал....12
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....12
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....13
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....14
   3.8 Аудитын гол асуудал....14
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....15
4. Аудитын илрүүлэлт ....15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....15


**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/80/НА-СТА-ТӨ/3
танай ____________-ны № ______________-т

УВС АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ТӨРТОГТОХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200300

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **38,839,173.00** | **41,611,494.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,839,173.00 | 41,611,494.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,661,295.00 | 11,563,266.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,661,295.00 | 11,563,266.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,972,878.00 | 16,068,228.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 550,468.00 | 675,818.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 465,660.00 | 465,660.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 410,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 243,000.00 | 243,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,713,750.00 | 14,273,750.00 |
| 35600 | Мал амьтад | 14,205,000.00 | 13,980,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,679,302,128.79** | **1,444,827,528.22** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | ,679,302,128.79 | 1,444,827,528.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,513,899,720.79 | 1,290,171,503.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 783,440,649.81 | 779,240,148.81 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (107,218,043.26) | (128,563,992.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 334,749,200.00 | 257,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (191,957,533.31) | (141,391,666.71) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,157,900,702.72 | 1,117,861,493.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (463,996,713.39) | (598,365,678.44) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,341,133.00 | 27,341,133.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (22,359,674.78) | (23,349,934.94) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 165,402,408.00 | 154,656,024.72 |
| 39301 | Програм хангамж | 43,635,533.00 | 43,635,533.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (753,125.00) | (11,499,508.28) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 122,520,000.00 | 122,520,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,718,141,301.79** | **1,486,439,022.22** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,718,141,301.79** | **1,486,439,022.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,718,141,301.79 | 1,486,439,022.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,836,065,647.36 | 1,836,065,647.36 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,836,065,647.36 | 1,836,065,647.36 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (317,966,147.83) | (549,668,427.40) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (904,835,006.51) | (317,966,147.83) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 586,868,858.68 | (231,702,279.57) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 200,041,802.26 | 200,041,802.26 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,718,141,301.79** | **1,486,439,022.22** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,549,853,372.00** | **856,437,750.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **716,423,372.00** | **7,525,050.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 716,423,372.00 | 7,525,050.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 716,353,372.00 | 7,455,050.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 716,353,372.00 | 7,455,050.00 |
| 120009 | Бусад орлого | 70,000.00 | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **833,430,000.00** | **848,912,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 833,430,000.00 | 848,912,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 833,430,000.00 | 842,616,700.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 0.00 | 6,296,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **906,049,077.62** | **1,073,380,191.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **906,049,077.62** | **1,073,380,191.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 868,227,062.80 | 1,048,715,065.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 588,466,351.56 | 627,801,894.96 |
| 210101 | Үндсэн цалин | 569,970,351.56 | 588,947,394.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,496,000.00 | 38,854,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 73,478,295.51 | 86,075,788.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,711,812.85 | 60,971,329.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,117,825.77 | 4,202,865.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,766,838.40 | 2,937,152.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,814,466.15 | 6,215,830.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,067,352.34 | 11,748,609.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,245,562.11 | 18,645,205.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,660,322.11 | 9,091,132.85 |
| 210302 | Түлш, халаалт | 9,585,240.00 | 9,301,363.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 252,710.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,630,049.00 | 33,829,191.00 |

Увс аймаг дахь Төрийн аудитын газар 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛ

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 3,486,050.00 | 3,293,330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,305,700.00 | 24,856,582.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,987,999.00 | 2,410,379.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 235,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,850,300.00 | 3,033,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,926,200.00 | 22,946,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 183,000.00 | 0.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 907,500.00 | 14,045,750.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,835,700.00 | 8,900,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,563,600.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,563,600.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,842,259.00 | 6,329,478.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,644,540.00 | 632,407.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,500,000.00 | 2,257,637.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 377,427.00 | 400,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 132,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,225,200.00 | 1,919,600.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 387,092.00 | 267,834.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 120,074,745.62 | 253,087,257.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,620,000.00 | 1,800,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 143,500.00 | 210,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 117,311,245.62 | 251,077,257.47 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 37,822,014.82 | 24,665,126.18 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,822,014.82 | 24,665,126.18 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | 0.00 | 2,296,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,822,014.82 | 22,369,126.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **643,804,294.38** | **(216,942,441.47)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 0.00 | 0.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 56,935,435.70 | 14,759,838.10 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 56,935,435.70 | 14,736,793.10 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 0.00 | 23,045.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (56,935,435.70) | (14,759,838.10) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **586,868,858.68** | **(231,702,279.57)** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **833,500,000.00** | **848,982,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **70,000.00** | **70,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 70,000.00 | 70,000.00 |
| 120009 | Бусад орлого | 70,000.00 | 70,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **833,430,000.00** | **848,912,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 833,430,000.00 | 848,912,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 833,430,000.00 | 842,616,700.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | 6,296,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **833,500,000.00** | **848,982,700.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **833,500,000.00** | **848,982,700.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **795,677,985.18** | **824,317,573.82** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 587,064,746.06 | 627,801,943.33 |
| 210101 | Үндсэн цалин | 334,203,914.78 | 371,743,414.29 |
| 210102 | Нэмэгдэл | 193,926,519.48 | 173,738,096.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 19,417,892.69 | 38,084,929.00 |
| 210104 | Урамшуулал | 39,516,419.11 | 44,235,503.10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,879,901.01 | 86,075,739.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,879,901.01 | 60,971,329.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 5,804,523.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 7,401,145.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 1,081,703.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 10,817,036.63 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,512,322.11 | 18,645,205.85 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,660,322.11 | 9,091,132.85 |
| 210302 | Түлш, халаалт | 9,302,000.00 | 9,301,363.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 550,000.00 | 252,710.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,668,049.00 | 34,635,591.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,055,750.00 | 3,413,730.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,667,700.00 | 24,981,582.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,987,999.00 | 2,410,379.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 235,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,956,600.00 | 3,594,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 62,325,700.00 | 50,740,950.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,358,300.00 | 3,064,500.00 |
| 210602 | Тавилга | - | 4,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,854,000.00 | 13,191,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 53,113,400.00 | 30,485,450.00 |

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,563,600.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,563,600.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,520,167.00 | 6,208,144.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,394,540.00 | 632,407.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,500,000.00 | 2,257,637.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 377,427.00 | 400,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | 132,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,225,200.00 | 1,919,600.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 315,000.00 | 146,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 143,500.00 | 210,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 143,500.00 | 210,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **37,822,014.82** | **24,665,126.18** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,822,014.82 | 24,665,126.18 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | - | 2,296,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,822,014.82 | 22,369,126.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | - |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | - |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,836,065,647.36 | 200,041,802.26 | -904,835,006.51 | 1,131,272,443.11 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,836,065,647.36** | **200,041,802.26** | **-904,835,006.51** | 1,131,272,443.11 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 586,868,858.68 | 586,868,858.68 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,836,065,647.36** | **200,041,802.26** | **-317,966,147.83** | 1,718,141,301.79 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,836,065,647.36** | **200,041,802.26** | **268,902,710.85** | 1,718,141,301.79 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,836,065,647.36** | **200,041,802.26** | **-317,966,147.83** | 1,718,141,301.79 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | - 231,702,279.57 | - 231,702,279.57 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,836,065,647.36** | **200,041,802.26** | **-549,668,427.40** | 1,486,439,022.22 |
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,836,065,647.36 | 200,041,802.26 | -904,835,006.51 | 1,131,272,443.11 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 848,982,700.00 | 824,317,573.82 | 24,665,126.18 | 97.1% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 848,516,700.00 | 824,317,573.82 | 22,362,126.18 | 97.1% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 848,516,700.00 | 824317573.82 | 22,362,126.18 | 97.1% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 635,501,500.00 | 627,801,943.33 | 7,699,556.67 | 98.8% |
| 210101 | Үндсэн цалин | 355,635,600.00 | 371,743,414.29 | -16,107,814.29 | 104.5% |
| 210102 | Нэмэгдэл | 190,292,400.00 | 173,738,096.94 | 16,554,303.06 | 91.3% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 41,573,500.00 | 38,084,929.00 | 3,488,571.00 | 91.6% |
| 210104 | Урамшуулал | 48,000,000.00 | 44,235,503.10 | 3,764,496.9 | 92.1% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 87,500,100.00 | 86,075,739.64 | 1,424,360.36 | 98.4% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,287,510.00 | 60,971,329.97 | -1,696,229.97 | 102.9% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,516,000.00 | 5,804,523.88 | -1,288,523.88 | 128.5% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,290,000.00 | 7,401,145.32 | 3,888,854.68 | 65.5% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,129,000.00 | 1,081,703.84 | 47,296.16 | 95.8% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,290,000.00 | 10,817,036.63 | 472,963.37 | 95.8% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,452,200.00 | 18,645,205.85 | 7,806,994.15 | 70.% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,400,000.00 | 9,091,132.85 | 6,308,867.15 | 59.0% |
| 210302 | Түлш, халаалт | 9,302,200.00 | 9,301,363.00 | 837.00 | 99.9% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,750,000.00 | 252,710.00 | 1,497,290.00 | 14.4% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,930,700.00 | 34,635,591.00 | 295,109.00 | 99.1% |
| 210401 | Бичиг хэрэг | 3,461,600.00 | 3,413,730.00 | 47,870.00 | 98.6% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,000,000.00 | 24,981,582.00 | 18,418.00 | 99.9% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,581,100.00 | 2,410,379.00 | 170,721.00 | 93.4% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 288,000.00 | 235,000.00 | 53,000.00 | 81.6% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,600,000.00 | 3,594,900.00 | 5,100.00 | 99.9% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 51,368,000.00 | 50,740,950.00 | 627,050.00 | 98.8% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,068,000.00 | 3,064,500.00 | 3,500.00 | 99.9% |
| 210602 | Тавилга | 4,000,000.00 | 4,000,000.00 | 0.00 | 100% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 13,800,000.00 | 13,191,000.00 | 609,000.00 | 95.6% |
| 210604 | Урсгал засвар | 30,500,000.00 | 30,485,450.00 | 14,550.00 | 99.9% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,800,000.00 | - | 3,800,000.00 | 0% |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,800,000.00 | - | 3,800,000.00 | 0% |

УВС АЙМАГ ДАХЬ ... ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,224,200.00 | 6,208,144.00 | 2,016,056.00 | 75.5% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 650,000.00 | 632,407.00 | 17,593.00 | 97.3% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 726,000.00 | 720,000.00 | 6,000.00 | 99.1% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,500,000.00 | 2,257,637.00 | 242,363.00 | 90.3% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 400,000.00 | 400,000.00 | 0.00 | 100% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 145,000.00 | 132,000.00 | 13,000.00 | 91.0% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 182,000.00 | 0.00 | 182,000.00 | 0% |
| 210807 | Газрын төлбөр | 1,920,800.00 | 1,919,600.00 | 1,200.00 | 99.9% |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,700,400.00 | 146,500.00 | 1,553,900.00 | 8.6% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 740,000.00 | 210,000.00 | 530,000.00 | 28.4% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 240,000.00 | 210,000.00 | 30,000.00 | 87.5% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 842,616,700.00 | 824,317,573.82 | 22,073,126.18 | |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 842,616,700.00 | 824,317,573.82 | 22,073,126.18 | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 842,616,700.00 | 820,543,573.82 | 22,073,126.18 | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,400,000.00 | 70,000.00 | 1,330,000.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,400,000.00 | 70,000.00 | 1,330,000.00 | |

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0.00 | 4,000,000.00 | -4,000,000.00 | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0.00 | 4,000,000.00 | -4,000,000.00 | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 4,000,000.00 | -4,000,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 4,000,000.00 | -4,000,000.00 | |
| 210602 | Тавилга | 0.00 | 4,000,000.00 | -4,000,000.00 | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 4,000,000.00 | -4,000,000.00 | |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймаг дахь Гаалийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Гаалийн Ерөнхий газрын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тус байгууллагын 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар 1 акт, 6 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 962,984.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,629.8 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,071,580.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 10,715.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,572.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 231,702.3 мянган төгрөгөөр буюу 13 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 38,839.2 | 41,611.5 | 2,772.3 |
| Үндсэн хөрөнгө | 1,679,302.1 | 1,444,827.5 | -234,474.6 |
| **Нийт хөрөнгө** | 1,718,141.3 | 1,486,43.02 | -231,702.3 |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,836,065.6 | 1,836,065.7 | 0.00 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,718,141.3 | 1,486,439.02 | -231,702.3 |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,611.5 мянган төгрөг болж 2,722.3 мянган төгрөгөөр өссөн нь халдвараас хамгаалах хэрэгслийн данс болох тусгай зориулалтын

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

материалын нөөц үүсгэж, зарцуулагдаагүй үлдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,444,827.5 мянган төгрөг болж 234,474.6 мянган төгрөгөөр буурахад урсгал төсвийн хөрөнгөөр 3,064.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4,000.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, бараа материалын данснаас шилжүүлэн авсан 3,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 21,175.0 мянган төгрөгийн барилга байгууламжийн капиталжуулалт хийгдэж, тайлант онд 251,077.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон, 71,000.0 мянган төгрөгийн хөрөнгө балансаас балансt шилжүүлж, нийт 77,928.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,486,439.0 мянган төгрөг болж 231,702.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 695,223.3 мянган төгрөгөөр буюу 45 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 165,531.1 мянган төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өсөхөд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал , ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, эд хогшил, урсгал засварын зардлуудын өсөлт болон байр ашиглалттай холбоотой тогтмол зардал , бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг зардлууд нөлөөлсөн байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймаг дахь Гаалийн газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 980,516.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 980,516.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 135,500.1 мянган төгрөгөөр бууруулж 845,016.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг бууруулж баталсантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 844,016.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 842,616.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,400.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 842,616.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 70.0 мянган төгрөг, нийт 842,686.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 820,317.6 мянган төгрөгийг зарцуулж 22,369.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 820,317.6 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймаг дахь Гаалийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн төсвөөс 6,296.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,000.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авч үлдэгдэл 2,296.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймаг дахь Гаалийн газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 147, хугацаа хоцроосон 2 мэдээлэл оруулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 1/48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар малын тооцоо бүртгэл, нас дэвшилт, зарлагын талаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Увс аймаг дахь Гаалийн газар | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| ДҮН | | | | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ